



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/277

Бат-Өлзий сум

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бүртгэж, хариуцуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бүртгэж, хариуцуулсан жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг хууль, журмын дагуу Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

3.Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Н.Орхонтуул* Н.ОРХОНТУУЛ



Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/277 дугаар захирамжийн хавсралт



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Үндсэн хөрөнгийн бүртгэлд авах байгууллага	Байршил	Хариуцах эзэн
	1	2	3	4	5
1	Бугатын зам засах	7,560.0	Засаг даргын Тамгын газар	Бүрэгтий 2 дугаар баг	2 дугаар багийн Засаг дарга
2	Хурдан морины уралдааны зам засах	18,000.0	Засаг даргын Тамгын газар	Бүрэгтий 2 дугаар баг, Зөрүүлэг 4 дүгээр баг	2, 4 дүгээр дугаар багийн Засаг дарга нар
3	Могойт мойлтын зам засах	9,900.0	Засаг даргын Тамгын газар	Өвт 3 дугаар баг	3 дугаар багийн Засаг дарга
4	Өвтийн Мөстийн зам засах	4,999.0	Засаг даргын Тамгын газар	Хүйтэн булаг 5 дугаар баг	5 дугаар багийн Засаг дарга
5	Жогом хороолол руу тог татах	80,487.9	Засаг даргын Тамгын газар	Хүйтэн булаг 5 дугаар баг	5 дугаар багийн Засаг дарга
6	Наадмын талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах	188,347.0	Засаг даргын Тамгын газар	Хүйтэн булаг 5 дугаар баг	5 дугаар багийн Засаг дарга
7	Гэрэлтүүлэг засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	37,805.1	Засаг даргын Тамгын газар	Өвт 3 дугаар баг, Хүйтэн булаг 5 дугаар баг	3, 5 дугаар багийн Засаг дарга нар
8	Бизнес хөгжлийн төвийн түрээсийн байрны засвар	10,000.0	Засаг даргын Тамгын газар	Өвт 3 дугаар баг	3 дугаар багийн Засаг дарга
9	Сумын төвд мал тарилгын хашаа барих	1,680.0	Засаг даргын Тамгын газар	Хүйтэн булаг 5 дугаар баг	5 дугаар багийн Засаг дарга
Дуусаагүй хөрөнгө					
10	Зөрүүлэг баг-Галт, Гуяын нуруу, Бүрэгтий баг Билүүтийн хөндлөн, Улиастай баг Улиастай дэнжид худаг /цооног/ гаргах	41,400.0	Засаг даргын Тамгын газар	Бүрэгтий 2 дугаар баг, Зөрүүлэг 4 дүгээр баг, Улиастай 6 дугаар баг	2, 4, 6 дугаар багийн Засаг дарга нар
11	3 өргөн чөлөөний зам арчилгаа	200,000.0	Засаг даргын Тамгын газар	Өвт 3 дугаар баг	3 дугаар багийн Засаг дарга
12	Тэжээлийн нөөц бүрдүүлэх	22,000.0	Засаг даргын Тамгын газар	Засаг даргын	Засаг даргын Тамгын газар

				Тамгын газар	
13	Бөөрөгт худаг гаргах	9,450,0	Засаг даргын Тамгын газар	Улиастай 6 дугаар баг	6 дугаар багийн Засаг дарга
14	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах	10,800.0	Засаг даргын Тамгын газар	Засаг даргын Тамгын газар	Засаг даргын Тамгын газар

---oOo---